

ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын эрүүл мэндийн төвийн
2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2025/093/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Мөрөн сум

2025 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Аудитор: Г.Ичинхорлоо

Утас:88688168 Цахим хаяг: ichinkhorloog@audit.gov.mn

Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн захирал Б.Мядагмаа

Утас:99389208 Цахим хаяг: b_myadagmaaa@yahoo.com

Аудитор Ц.Мөнхтуяа

Утас: 99382220 Цахим хаяг: munkhtuya2220@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЦАГААНУУР
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА
Ө.ОТГОНГЭРЭЛ ТАНАА

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.08.25 № 1/170
танай _____ -ны № _____ -т

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Цагааннуур сумын эрүүл мэндийн төв нь 2024 онд Эрүүл мэндийн даатгалын сангаас 810,051.2 мянган төгрөгийн санхүүжилтийг авахаас 782,214.2 мянган төгрөгийн санхүүжилтийг авч 27,837.0 мянган төгрөгийн авлагатай гарсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар нийт 65,291.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 238.7 мянган төгрөгийн 1 акт, 1 албан шаардлага, 4 зөвлөмж өгч, 65,053.2 мянган төгрөгийн 4 алдааг илрүүлэн залруулсан.

Бусад асуудлын хэсэг

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас Цагааннуур сумын эрүүл мэндийн төвтэй байгуулсан анхан шатны тусламж үйлчилгээг худалдан авах 2024 оны гэрээний биелэлтийг 82.0 хувьтай дүгнэсэн байна.

6705901512

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
		/төгрөгөөр/	
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>101,825,726.83</u>	<u>151,859,649.33</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	8,423,097.86	111,163.12
312	Банканд байгаа бэлэн мөнгө	8,423,097.86	111,163.12
3121	Төгрөг	8,423,097.86	111,163.12
31211	Төрийн сангийн харилцах	8,423,097.86	111,163.12
33	АВЛАГА	0.00	31,320,942.37
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	0.00	505,305.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	0.00	27,837,038.23
335	Бусад авлага	0.00	2,978,599.14
3351	Байгууллагаас авах авлага	0.00	2,978,599.14
35	БАРАА МАТЕРИАЛ	93,402,628.97	120,427,543.84
351	Түүхий эд материал	32,188,965.52	37,750,208.89
35130	Эм боох материал	32,188,965.52	37,750,208.89
354	Хангамжийн материал	61,213,663.45	82,677,334.95
35410	Бичиг хэргийн материал	1,229,950.00	1,405,450.00
35420	Аж ахуйн материал	15,507,209.33	18,267,959.33
35430	Сэлбэг хэрэгсэл	401,750.00	5,856,000.00
35440	Түлш, шатах тослох материал	8,507,242.60	14,825,839.60
35450	Барилгын засварын материал	8,195,700.00	9,556,100.00
35460	Хүнсний материал	589,687.40	3,416,358.90
35470	Бусад хангамжийн материал	26,782,124.12	29,349,627.12
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>390,772,503.50</u>	<u>354,927,963.97</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	390,772,503.50	354,927,963.97
392	Биет хөрөнгө	371,678,503.38	335,913,963.77
39201	Барилга, байгууламж, орон сууц	296,226,943.82	296,226,943.82
39202	Хуримтлагдсан элэгдэл	(77,972,614.98)	(90,660,552.98)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	103,112,533.00	103,112,533.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(65,926,254.35)	(86,863,361.03)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	247,441,733.50	291,801,793.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	(139,656,096.30)	(183,004,568.34)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	15,152,200.00	15,152,200.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(6,699,941.31)	(9,851,024.20)
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,529,000.00	1,529,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,529,000.00)	(1,529,000.00)
393	Биет бус хөрөнгө	19,094,000.12	19,014,000.20
39301	Программ хангамж	400,000.00	400,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(119,999.88)	(199,999.80)
39303	Бусад биет бус хөрөнгө	18,814,000.00	18,814,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>492,598,230.33</u>	<u>506,787,613.30</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>18,164,075.79</u>	<u>7,967,463.87</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	18,164,075.79	7,967,463.87
413	Өглөг	18,164,075.79	7,967,463.87
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	4,296,741.95	3,490,345.39
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,797,241.14	4,282,475.64
4136	Бусад өглөг	12,070,092.70	194,642.84
41361	Байгууллагад төлөх өглөг	12,070,092.70	194,642.84
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>474,434,154.54</u>	<u>498,820,149.43</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	474,434,154.54	498,820,149.43
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	265,519,675.00	265,519,675.00

51101	Өмч: - төрийн	265,519,675.00	265,519,675.00
512	Хуримтлагдсан үр дүн	144,975,882.04	169,361,876.93
51210	Өмнөх үеийн үр дүн	144,975,882.04	144,975,882.04
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	24,385,994.89
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	63,938,597.50	63,938,597.50
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	492,598,230.33	506,787,613.30

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	612,764,737.35	951,397,809.44
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	38,849,285.37	85,042,525.41
120	Нийтлэг татварын бус орлого	38,849,285.37	85,042,525.41
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	38,849,285.37	85,042,525.41
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	21,486,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	38,849,285.37	63,556,525.41
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	573,915,451.98	866,355,284.03
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	36,250,000.00	45,520,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	36,250,000.00	45,520,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	537,665,451.98	820,835,284.03
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	537,665,451.98	820,835,284.03
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	722,668,107.85	927,011,814.55
21	УРСГАЛ ЗАРДАЛ	722,668,107.85	927,011,814.55
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	722,665,440.86	905,508,175.32
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	416,013,551.10	600,355,738.53
210101	Үндсэн цалин	282,018,288.98	321,172,009.03
210102	Нэмэгдэл	78,402,000.00	217,395,616.02
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,559,129.35	19,501,113.48
210104	Урамшуулал	51,034,132.77	42,287,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51,920,113.23	64,208,258.91
210201	Тэтгэврийн даатгал	26,192,830.24	42,022,058.91
210202	Тэтгэмжийн даатгал	16,579,061.69	5,450,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,312,685.67	2,789,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,294,821.44	2,789,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,540,714.19	11,157,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,653,420.00	33,512,903.61
210301	Гэрэл, цахилгаан	4,077,213.01	4,282,503.61
210302	Түлш, халаалт	29,576,206.99	28,130,400.00
210303	Цэвэр, бохир ус	0.00	1,100,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	43,805,268.37	36,758,663.50
210401	Бичиг хэрэг	11,506,002.00	3,262,080.00
210402	Тээвэр, шатахуун	28,527,859.37	29,245,063.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,420,000.00	2,925,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,343,007.00	1,175,550.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	8,400.00	0.00
210408	Бараа материал акталсны зардал	0.00	150,970.50
2105	Нормативт зардал	81,234,564.97	62,011,937.24
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	66,712,250.37	48,360,066.74
210502	Хоол, хүнс	14,522,314.60	13,651,870.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,415,552.14	18,068,830.00
210604	Урсгал засвар	16,415,552.14	18,068,830.00
2107	Томиллолт, зочны зардал	2,930,999.00	5,050,800.00
210702	Дотоод албан томиллолт	2,930,999.00	5,050,800.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,082,680.00	2,152,494.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	80,000.00	72,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,872,000.00	1,152,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	130,680.00	54,500.00
210807	Газрын төлбөр	0.00	41,520.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	0.00	832,474.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	74,609,292.05	83,388,549.53
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	145,000.00	3,183,950.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	74,464,292.05	80,204,599.53
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,666.99	21,503,639.23
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	21,246,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.00	21,246,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,666.99	257,639.23
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,666.99	257,639.23
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(109,903,370.50)	24,385,994.89
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	20,000.00	0.00
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	20,000.00	0.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	20,000.00	0.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(109,883,370.50)	24,385,994.89

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	584,699,544.68	849,220,153.10
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	21,486,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	21,486,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	21,486,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	21,486,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	584,699,544.68	827,734,153.10
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	36,250,000.00	45,520,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	36,250,000.00	45,520,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	548,449,544.68	782,214,153.10
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	548,449,544.68	782,214,153.10
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	591,162,793.50	856,575,087.84
21	УРСГАЛ ЗАРДАЛ	591,162,793.50	856,575,087.84
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	591,160,126.51	835,071,448.61
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	406,014,242.36	599,906,698.14
210101	Үндсэн цалин	264,757,460.80	320,722,968.64
210102	Нэмэгдэл	80,423,442.57	217,395,616.02
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,743,216.73	19,501,113.48
210104	Урамшуулал	51,090,122.26	42,287,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,295,160.02	69,603,700.00
210201	Тэтгэврийн даатгал	38,678,603.46	47,417,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,379,032.97	5,450,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,329,479.48	2,789,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	921,723.42	2,789,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,986,320.69	11,157,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,747,333.01	40,262,360.77
210301	Гэрэл, цахилгаан	3,749,114.95	4,742,360.77
210302	Түлш, халаалт	27,499,120.00	34,420,000.00

/төгрөгөөр/

210303	Цэвэр, бохир ус	1,499,098.06	1,100,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	28,934,328.20	36,253,440.00
210401	Бичиг хэрэг	944,000.00	4,054,380.00
210402	Тээвэр, шатахуун	23,845,328.20	29,274,060.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,420,000.00	2,925,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,125,000.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	600,000.00	0.00
2105	Нормативт зардал	42,634,913.92	51,692,425.70
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	25,544,863.92	31,724,280.70
210502	Хоол, хүнс	13,092,050.00	18,468,145.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,998,000.00	1,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,644,800.00	26,640,580.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,000,000.00	2,891,000.00
210604	Урсгал засвар	9,644,800.00	23,749,580.00
2107	Томилолт, зочны зардал	2,930,999.00	5,050,800.00
210702	Дотоод албан томилолт	2,930,999.00	5,050,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,148,950.00	2,152,494.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	80,000.00	72,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,872,000.00	1,152,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	130,680.00	54,500.00
210807	Газрын төлбөр	41,520.00	41,520.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,024,750.00	832,474.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,809,400.00	3,508,950.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,809,400.00	3,508,950.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,666.99	21,503,639.23
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	21,246,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.00	21,246,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,666.99	257,639.23
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,666.99	257,639.23
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(6,463,248.82)	(7,354,934.74)
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	8,885,000.00	957,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	8,885,000.00	957,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	8,885,000.00	957,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	8,885,000.00	957,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(8,885,000.00)	(957,000.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(15,348,248.82)	(8,311,934.74)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	23,771,346.67	8,423,097.86
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	8,423,097.86	111,163.12

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2013 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	265,519,675.00	63,938,597.50	254,859,252.54	584,317,525.04

Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	(109,883,370.50)	(109,883,370.50)
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	265,519,675.00	63,938,597.50	144,975,882.04	474,434,154.54
2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	265,519,675.00	63,938,597.50	144,975,882.04	474,434,154.54
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	24,385,994.89	24,385,994.89
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	265,519,675.00	63,938,597.50	169,361,876.93	498,820,149.43

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан
Улсын төсвийн гүйцэтгэл:

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	889,908,900.00	812,012,087.84	91.25	77,896,812.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	889,908,900.00	812,012,087.84	91.25	77,896,812.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	809,908,900.00	790,766,087.84	97.64	19,142,812.16
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	610,023,000.00	599,906,698.14	98.34	10,116,301.86
210101	Үндсэн цалин	285,303,200.00	320,722,968.64	112.41	(35,419,768.64)
210102	Нэмэгдэл	262,912,500.00	217,395,616.02	82.69	45,516,883.98
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,091,300.00	19,501,113.48	241.01	(11,409,813.48)
210104	Урамшуулал	53,716,000.00	42,287,000.00	78.72	11,429,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	69,731,700.00	69,603,700.00	99.82	128,000.00
210201	Тэтгэврийн даатгал	47,530,800.00	47,417,500.00	99.76	113,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,550,200.00	5,450,700.00	98.21	99,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,775,100.00	2,789,200.00	100.51	(14,100.00)
210204	Ажилгүйдлийн даатгал	2,775,100.00	2,789,200.00	100.51	(14,100.00)
210205	Эрүүл мэндийн даатгал	11,100,500.00	11,157,100.00	100.51	(56,600.00)
2104	Хангамж, бараа материалын зардал	39,557,200.00	36,253,440.00	91.65	3,303,760.00
210401	Бичиг хэрэг	4,308,700.00	4,054,380.00	94.10	254,320.00
210402	Тээвэр, шатахуун	32,232,400.00	29,274,060.00	90.82	2,958,340.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,016,100.00	2,925,000.00	96.98	91,100.00
2105	Нормативт зардал	52,225,900.00	51,692,425.70	98.98	533,474.30
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	32,167,000.00	31,724,280.70	98.62	442,719.30
210502	Хоол, хүнс	18,558,900.00	18,468,145.00	99.51	90,755.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.00	1,500,000.00	100.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,750,000.00	21,640,580.00	95.12	1,109,420.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,000,000.00	2,891,000.00	72.28	1,109,000.00
210604	Урсгал засвар	18,750,000.00	18,749,580.00	100.00	420.00
2107	Томилолт, зочны зардал	5,149,700.00	5,050,800.00	98.08	98,900.00
210702	Дотоод албан томилолт	5,149,700.00	5,050,800.00	98.08	98,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,879,800.00	2,152,494.00	55.48	1,727,306.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	332,900.00	72,000.00	21.63	260,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,500,000.00	1,152,000.00	76.80	348,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	100,000.00	0.00	0.00	100,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	200,000.00	54,500.00	27.25	145,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	150,000.00	0.00	0.00	150,000.00
210807	Газрын төлбөр	500,000.00	41,520.00	8.30	458,480.00

210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,096,900.00	832,474.00	75.89	264,426.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,591,600.00	4,465,950.00	67.75	2,125,650.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,591,600.00	4,465,950.00	67.75	2,125,650.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	80,000,000.00	21,246,000.00	26.56	58,754,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	80,000,000.00	21,246,000.00	26.56	58,754,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	80,000,000.00	21,246,000.00	26.56	58,754,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	889,908,900.00	803,700,153.10	90.31	86,208,746.90
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	803,067,700.00	782,214,153.10	97.40	20,853,546.90
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	803,067,700.00	782,214,153.10	97.40	20,853,546.90
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	86,841,200.00	21,486,000.00	24.74	65,355,200.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	80,353,900.00	21,486,000.00	26.74	58,867,900.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	6,487,300.00	0.00	0.00	6,487,300.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	8,423,097.86		(8,423,097.86)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	111,163.12		(111,163.12)

Орон нутгийн төсвийн гүйцэтгэл:

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/ төгрөгөөр /	
				Хувь	Зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	45,520,000.0	45,262,360.8	99.4	257,639.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	45,520,000.0	45,262,360.8	99.4	257,639.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	45,520,000.0	45,262,360.8	99.4	257,639.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,520,000.0	40,262,360.8	99.4	257,639.2
210301	Гэрэл, цахилгаан	5,000,000.0	4,742,360.8	94.8	257,639.2
210302	Түлш, халаалт	34,420,000.0	34,420,000.0	100.0	0.0
210303	Цэвэр, бохир ус	1,100,000.0	1,100,000.0	100.0	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,000,000.0	5,000,000.0	100.0	0.0
210604	Урсгал засвар	5,000,000.0	5,000,000.0	100.0	0.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	45,520,000.0	45,262,360.8	99.4	257,639.2
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	45,520,000.0	45,262,360.8	99.4	257,639.2
320001	Орон нутгийн төсвөөс	45,520,000.0	45,262,360.8	99.4	257,639.2

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 65,291.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 238.7 мянган төгрөгийн 1 акт, 1 албан шаардлага, 5 зөвлөмж өгч, 65,053.2 мянган төгрөгийн 4 алдааг илрүүлэн залруулсан.

3.1 Залруулсан алдаа

- Эрүүл мэндийн газраас санхүүжсэн тэтгэмжийн санхүүжилт 21,486.0 мянган төгрөгийг буруу бүртгэснийг Сангийн сайдын 2025 оны А/3 тушаалаар баталсан "Төсвийн

байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу залруулга хийсэн.

- ЭМЯ-аас үнэ төлбөргүй хүлээлгэн өгсөн 40,178.0 мянган төгрөгийн, ОНӨГ-ийн даргын тушаалаар үнэ төлбөргүй хүлээлгэн өгсөн 495.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн тус тус нягтлан бодох бүртгэлд бүртгээгүй байгаа нь тулган баталгаажуулалтаар илэрсэн. Энэ нь "Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 заалт "үнэн зөв байх;" заалттай нийцэхгүй "үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байх тул хөрөнгийг орлого болгож залруулга хийсэн.
- Төсвийн гүйцэтгэлийн төлөвлөгөө 2,636.6 мянган төгрөгөөр зөрүүтэй байсныг залруулсан.
- Орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн шилжүүлэг 257.6 мянган төгрөгийг бүртгээгүй, харилцах дансны үлдэгдэл зөрүүтэй байсныг залруулга хийсэн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 238.7 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 11,562.7 мянган төгрөгөөс 11,324.0 мянган төгрөгөөр бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

3.2 Төлбөрийн акт

Байгууллагын даргын тушаалаар сахилгын шийтгэлтэй 2 ажилтанд 238.7 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3-р хавсралт "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.7. "Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй". заалттай нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангаагүй байна.

3.3 Албан шаардлага

- Өмнөх аудитаар өгсөн Шилэн дансны мэдээллийн тухай бүр байршуулж байх, зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүйгээс Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 11 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн, орлогын 9 гүйлгээ, зарлагын 1 гүйлгээг огт мэдээлээгүй, өмнөх зөвлөмжийг хэрэгжүүлээгүй нь "Шилэн дансны тухай" хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;" заалт, 6 дугаар зүйлийн 6.1."Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ:", 6.4."Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:" заалт, Үндсэн хөрөнгө болон бараа материалын үлдэгдлийг тооллогоор баталгаажуулж байх албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, 2024 оны тооллогын бүртгэл хийгээгүй, ирүүлээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6. "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах"заалт болон "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Цагааннуур сумын эрүүл мэндийн төвийн мөрдөж байгаа Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь гүйцэтгэлийн санхүүжилтэд шилжсэнтэй холбоотой болон бусад шинээр гарсан дүрэм, журамтай нийцэхгүй болсон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана." заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинээр гарсан дүрэм, журамтай нийцүүлэн шинэчлэн боловсруулж, мөрдөх.

2. Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийн асуудал

Илрүүлэлт:

Цагааннуур сумын ЭМТ нь 2024 онд 850,223.7 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын байгууллагаас нэхэмжилснээс 29,388.5 мянган төгрөг хасагдсан, санхүүжилт дутуугаас 31,320.9 мянган төгрөгийн авлага, 7,967.5 мянган төгрөгийн өглөгтэй тайлагнасан байна. Энэ нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6 "эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх даатгуулагчийн төлбөрийн тайлан тооцоо, холбогдох баримт бичгийг үнэн зөв, цаг хугацаанд нь гаргаж эрүүл мэндийн даатгалын байгууллагад ирүүлэх;" Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны "Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай" 05 дугаар тогтоолын 3.1 "Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хяналт, санхүүжилт, төлбөр тооцооны программ, цахим системийг бодит цагийн горимд шилжүүлж..." гэсэн заалт, Төсвийн тухай хуулийн уудтай тус тус нийцэхгүй "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хяналт, санхүүжилт, төлбөр тооцооны цахим системийн дотоод хяналтыг сайжруулж, хасагдалтын хэмжээг өмнөх оноос бууруулах, өр төлбөр, авлагагүй ажиллах.

3. Ахмадын сангийн талаар

Илрүүлэлт:

Цагааннуур сумын эрүүл мэндийн төв нь ахмадын сан байгуулаагүй байгаа нь Ахмадын настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 "Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах..." гэж заасантай нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Ахмадын санг байгууллагын төсөвт тусгаж батлуулах, Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан журмыг мөрдөж ажиллах

4. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэлийн талаар

Илрүүлэлт:

Төсвийн жилд худалдан авсан бараа, ажил үйлчилгээний тайланг гаргаж ирүүлээгүй, tender.gov.mn цахим хуудас, shilendans.gov.mn цахим хуудсанд байршуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5.3 заалтад заасан “тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл;” заалтыг хэрэгжүүлээгүй, “нийцсэн болон зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн жилд худалдан авсан бараа, ажил үйлчилгээний тайлан, гүйцэтгэл гаргаж санхүүгийн тайлангийн бүрэлдэхүүнд ирүүлж байх, tender.gov.mn цахим хуудас, shilendans.gov.mn цахим хуудсанд байршуулж мэдээлж байх.

5. Байгууллагын дотоод хяналтын талаар

Илрүүлэлт:

Байгууллагын дотоод хяналтын төлөвлөгөө, хэрэгжилтийн тайлан ирүүлээгүй, аудитын явцад илэрсэн зөрчил нь дотоод хяналт үр нөлөөгүй байгаа нь 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.7.1-дэх заалттай нийцэхгүй байгаа ба үнэн ба зөв гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Байгууллагын дотоод хяналтын төлөвлөгөө батлан хэрэгжилтийг ханган ажиллах.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хөрөнгө орлого болгоогүй алдааг залруулсан	2	40,673.0			2	40,673.0	2	40,673.0		
Санхүүжилтийн орлогын бичилт буруу байсныг залруулсан	2	24,380.2			2	24,380.2	2	24,380.2		
Дүн	4	65,053.2			4	65,053.2	4	65,053.2		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинээр гарсан дүрэм, журамд нийцүүлэн шинэчлээгүй.	1	-						1	-
Сахилгын шийтгэлтэй 2 ажилтанд 238,720.0 төгрөгийн цалин тооцож олгосонд төлбөрийн акт тогтоосон	1	238.7	1	238.7					
Дүн	2	238.7	1	238.7				1	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
www.shilendans.gov.mn цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 11 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн, орлогын 9 гүйлгээ, зарлагын 1 гүйлгээг огт мэдээлээгүй, өмнөх зөвлөмжийг хэрэгжүүлээгүй	1	-			1	-		
Тайлант жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг цахим системд оруулж, батлуулаагүй	1	-					1	-
Эмнэлгийн тусламж үйлчилгээний гүйцэтгэлийг цахим системд бүрэн, үнэ зөв оруулаагүйгээс нэхэмжилсэн санхүүжилтийг бүрэн авч чадаагүй.	1	-					1	-
Ахмадын санг байгууллагын төсөвт тусгаж, батлуулаагүй байна.	1						1	-
Байгууллагын дотоод хяналтын төлөвлөгөө, хэрэгжилтийн тайлан ирүүлээгүй.	1						1	
Дүн	5	-			1	-	4	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АКТ

2025 оны 02 сарын 25 өдөр

№ 08/А2270469/

Мөрөн сум

ХАА - 2025/093/НА-ОА-ЛУЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цагааннуур сумын Эрүүл мэндийн төвийн даргын тушаалаар сахилгын шийтгэлтэй 2 ажилтанд 238,720 (Хоёр зуун гучин найман мянган долоон зуу хорин) төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3-р хавсралт "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.7. "Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй" заалттай нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаал "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.5 төсвийн орлого, зарлагыг буруу тооцоолсон төсөвт зардлыг хэтрүүлсэн" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Байгууллагын даргын тушаалаар сахилгын шийтгэлтэй 2 ажилтанд үр дүнгийн урамшуулалд олгосон 238,720 (Хоёр зуун гучин найман мянган долоон зуу хорин) төгрөгийг Хөвсгөл аймгийн Орон нутгийн орлогын Төрийн сан дахь 1001700955 тоот дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг төрийн аудитын байгууллагын Fas.audit.mn цахим системд 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор нотлох баримтын хамт оруулж, баталгаажуулахыг Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын Эрүүл мэндийн төвийн дарга Ө.Отгонгэрэл, нягтлан бодогч Г.Цэцэгмаа нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

Г.ИЧИНХОРЛОО

6724020624



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

№ 55/А2270469/

Мөрөн сум

ХАА-8026/093/МӨ-СГА-1143

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Цагааннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Өмнөх аудитаар өгсөн Шилэн дансны мэдээллийг тухай бүр байршуулж байх, зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүйгээс Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 11 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн, орлогын 9 гүйлгээ, зарлагын 1 гүйлгээг огт мэдээлээгүй, өмнөх зөвлөмжийг хэрэгжүүлээгүй нь "Шилэн дансны тухай" хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;" заалт, 6 дугаар зүйлийн 6.1."Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ:", 6.4."Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:" заалтыг хэрэгжүүлээгүй.

2. Үндсэн хөрөнгө болон бараа материалын үлдэгдлийг тооллогоор баталгаажуулж байх албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, 2024 оны тооллогын бүртгэлийг ирүүлээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6. "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" заалт болон "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, акт тогтоох журам"-ын 44.2.1.10-т "Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийн хугацаанд нь хэрэгжүүлээгүй гэж үзсэн бусад нөхцөл", 4.2.1.2 "Хөрөнгийн тооллогыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны мэдээллийг тухай бүр байршуулж аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж байх, 2024 оны тооллогыг хийж тооллогын бүртгэлээр баталгаажуулах, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 20-ны дотор гаргаж, төрийн аудитын байгууллагын Fas.audit.mn цахим системд оруулж, баталгаажуулах;

2. Цаашид гарсан алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цагаан нуур сумын Эрүүл мэндийн төвийн дарга Ө.Отгонгэрэл, нягтлан бодогч Г.Цэцэгмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

6724020574
Г.ИЧИНХОРЛОО